

## АЛТАЙ СУДЛАЛ: КАЗАХ, МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ НЭГДМЭЛ БОЛОХ НЬ

*М.Хурметхан\**

Алтай судлалын үндсэн асуудал бол алтай хэлүүдийн гарал үүсэл нь нэг хэлнээс салбарлан хөгжсөн үү, эсвэл олон хэлүүд сүүлд өөр хоорондоо холилдон, нэгдмэл элементүүд бий болсон уу гэдэгт хариу өгөх явдал байдаг нь эрдэмтэд тодорхой билээ. Тэгээд ч алтай язгуурын хэлүүдийн нэгдмэл элементүүдийн талаар маргаантай, нэг мөр болсон онолын дүгнэлт гараагүй, эрдэмтэд судалгаагаа үргэлжүүлсээр байгааг хэлэх хэрэгтэй юм.

Хэл шинжлэлийн энэхүү асуудалд онолын хувьд хариу өгөхийг тус өгүүлэлдээ тусган харуулахыг оролдов. Тэгэхдээ, алтай хэлүүдийн талаархи урьд өмнөх шинжлэх ухааны ололтууд ялангуяа, казах-монгол хэлний гарал үүслийн талаархи уламжлалт хэл шинжлэлийн бүтээлүүдэд тулгуурласан болно. Энд алтайн бие даасан хоёр хэл нэгдмэл гарал үүсэлтэй эсэхийг судлан тогтоосноор ерөнхий алтай хэлний үндсэн маргааныг шийдвэрлэхэд бодит алхам болох билээ.

“Как известно, для констатции генетического родства двух или более языков необходимы следующие условия:

- наличие между этими языками системы регулярных фонетических соответствий,

- наличие достаточно большого количества совпадающей базисной лексики, на множестве которой выполняются упомянутые регулярные фонетические соответствия:

- желательно также наличие достаточно большого числа совпадающих грамматических морфем, на множестве которых также выполняются регулярные фонетические соответствия .

Историческая фонетика и морфология алтайских языков разработана довольно подробно. Известны многочисленные фонетические, морфологические, лексические и синтаксические параллели, глубинная структурная близость этих языков также не вызывает никаких сомнений”<sup>1</sup> гэж судлаачид тэмдэглэжээ. Гэвч энэ бүхэн нь тэдгээр хэлүүдийн нэгдмэл гарал үүслийг батлах бүрэн баталгаа болж чадахгүй билээ. Алтай хэлнүүдээс илүү ойр төрлийн хэлүүд болох казах-монгол хэлийг цаг хугацаа, хөдөлгөөний хүчин зүйлийг анхааран, бүх түвшинд бүрэн харьцуулан судалсанаар алтай хэлүүдийн гарал үүслийн талаархи үзэл баримтлалыг нягтлахад санаа нэмэрлэх явдал тус өгүүллйн гол зорилго юм.

\* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Биосферийн хөгжлийн явцад хүн үүсчээ. Хүний хөгжилд түүний сэтгэхүй болон хэлний хөгжил шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Хэл бол байгаль-хүн-сэтгэхүй-нийгэм-угсаатан болон цаг хугацаа-орон зай-хөдөлгөөний явцыг тусгасан байгаль-нийгмийн үзэгдэл ажээ. Дэлхийн аль ч ард түмний хэл нь дэлхийн гадаргуу, агаар мандлын доод хэсэгтээ, хүн, хүний сэтгэхүй, нийгмийн амьдралд түшиглэн бий болж, өөрчлөгдөж, оршин тогтнож байна. Анхны хүн сүрэг Африкт бий болж, дэлхийн өнцөг булан бүрт дэлгэрсэн гэх үзэл давамгайлах боловч, Төв Азид хүн дүрст мич 2-3 сая жилийн өмнө байж, эволюцийн хөгжилд “Homosapines”-ийн нэг төрөл бий болсон байж болзошгүй гэж зарим эрдэмтэд үзэж байгаа юм.

Дэлхийн аливаа хэл нь үүсэж бий болж, хөгжих явцад тэдгээрт гадаад, дотоод хүчин зүйлс нөлөөлсөөр иржээ. Гадаад хүчин зүйл нь цаг хугацаа, орон зай, хөдөлгөөнд хамааралтай бол дотоод хүчин зүйл нь хэлний өөрийн хуульд хамаарагдана. Тухайлбал, цаг хугацааны хувьд аливаа хэлний хөгжил урт удаан цагийг эзэлдэг бөгөөд тэдгээрийн үүсэл, хөгжлийн явц нь явган хүний үе /нэн эртнээс м.э.ө III/, их хээр талын морьтны үе /м.э.ө II-1522/, техникт суурилсан үе /1522-1961/, Сансар буюу интернетийн /1961-одоо/ үед хамаарагдана. Явган хүний үе алтай хэлэнд хамгийн урт түүхийг эзэлдэг бөгөөд явсан хүн ойролцоогоор өдөрт 60 км зам тулдаг гэж үзвэл эргэн тойрондоо арваас 100 км-д л информации түгээх бололцоотой бөгөөд энэ нь хэлний тархацад нөлөөлдөг юм.

Энэ нь информаши зааглагдан нэг эхлэлээс бие даасан хэл буюу аялгуу үүсэх шалтгаан болов. Өөрөөр хэлбэл, хэл нь биосферийн нөхцөлд индивидуалийн сигнализаци боловсруулах болон хүлээн авч хариу хийж харилцах боломжит боломж билээ. Иймээс алтай хэлүүдэд биосферийн нөхцөлд тулгуурласан ижил төстэй элемент ч, гарал үүсэл нэгтэй элемент ч, сүүлд бие биендээ шилжсэн элемент ч, бүр огт холбогдолгүй өвөрмөц элемент ч байгааг ажиглаж болох билээ.

- Орон зайн хувьд алтай язгуурын хэлээр ярилцагчид Туркээс Номхон далай, Сибирээс Энэтхэг хүртэлх удам нутагт тархан суурьшжээ. Одоо алтай язгуурын хэлээр 600 сая орчим хүн ярилцаж байна.

- Хөдөлгөөний хувьд үндсэндээ баруунаас дорно зүг юм уу дорно зүгээс баруун зүг чиглэсэн бололтой бөгөөд цаг хугацааны уртад хэд хэдэн голомтоос зүг зүг тархан хөгжиж, харилцан нийлж, салж хөгжиж байжээ.

- Антропологийн хувьд монголжуу болон европ-монголжуу холимог төрхтний салаа мөчрүүдэд хуваагдана.

- Угсаатан үндэстний хувьд түрэг, монгол, тунгус-манж, япон, солонгосыг багтаажээ.

Алтай хэлүүд дэлхийн гадаргуйн тодорхой орон зай дахь тодорхой угсаатны хүн амын харилцааны явцад цаг хугацааны урт

замыг туулан хөгжсөн оршин тогтнож буй хэлүүд юм. Алтай хэлүүдийн оршин тогтнож хөгжих гол хүчин зүйл нь тэдгээрийг тээгч угсаатан, үндэстэн хийгээд хэлний өөрийн өвөрмөц хууль юм. Алтай хэлүүд дэлхийн аль ч ард түмний хэлний нэг адил фонем, морфем, үг, өгүүлбэр гэсэн хэлний бүтцийн үндсэн дөрвөн нэгжээс бүрддэг нь хүн төрөлхтөний хэл нь нэгдмэл үндэстэй, тээгч хүн, үүсэн бий болох, оршин тогтнох нөхцөл, адил байгаа зэрэг түгээмэл зүйлүүдээр тодорхойлогдоно. Мөн түүнчилэн дэлхийн хэлнүүд дээр эдгээр үндсэн нэгжүүд харилцан адил, адилгүй байдлаар эмх цэгц, хэмнэлт зэрэг олон зүй үндсийг бүрдүүлсэн байна.

Алтай язгуурын хэл нь ерөнхий дүр төрх нь бүх элементүүдээ цувруулан холбох замаар бодол санаагаа дамжуулах, хүлээн авах зарчимд тулгуурлажээ. Энэхүү зарчим нь алтай язгуурын хэлүүд /түрэг, монгол, тунгус-манж, япон, солонгос хэл/ “нэг хэлнээс тархан, гарал үүсэл нэг, нэг язгуурын хэл” гэх буюу “бие даасан хэлүүд байгаад сүүлд холилдсоны үр дүнд нэгдмэл элементүүд бий болсон” гэсэн хоёр үзэл чиглэл бий болгоход хүргэсэн байна. Дээрх хэлнүүдийн санаагаа илэрхийлэх зарчим, түүний бодит илэрхийлэл нь тэдгээр нь нэгдмэл нэг язгуураас салаалан хөгжсөн хэл болох юм уу эсвэл тухайн хэлний өөрийн дотоод хөгжлийн үр дүнд бий болсон үндсэн элемент, тэр нь нөгөө хэлний элементтэй адил төстэй байх /хүн, өгүүлэх эрхтэн адил зохион байгуулалттай дамжуулах нөхцөл/ зэрэг нь үүнийг нөхцөлдүүлнэ. Хүний дуу авианд давтамж, агаарын дуу нэвтрэх магадлалтай холбоотой болохоос сүүлд хэлнүүд холилдон нэгдмэл элемент гарч ирэх үндэс нилээд хязгаарлагдмал юм. Иймд эдгээр хэлнүүдийн адил элементүүд нь нэг үүсвэрээс эх аван цаашид бие даан хөгжсөн эсвэл биосфер, хүний ерөнхий өгөгдөхүүний боломжинд тулгуурлан гарцаагүй тийм элементтэй байх явдалд тулгуурлах боломжтой юм. Ер нь алтай хэлүүдийг тээгчид нэгдмэл орон зайд хөрш зэргэлдээ тархсан болон антропологийн хэв шинж гэх мэт зүйлүүд нь хэлний ижил төстэй элементийн нөгөө талыг харуулж байдаг.

Алтай язгуурын хэл хэмээн нэрлэгдсэн хэлүүдийг судлаачид тэдгээр хэлний авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, үгсийн сангийн талаар харьцуулан судлаж, ижил төстэй олон зүйлийг шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ. Гэвч тэдгээр судалгаанууд зөвхөн синхрон байр сууринаасаа авч үзэж уламжлалт хоёр үзлийн аль нэгийг ягштал баримтлахад оршиж ирэв.

Алтайстикад ижил элементүүдийн жинхэнэ “эх” нь хаана байгаа болон диахрон /цуваа/ цагийн хүчин зүйл, хэл бүрт байгаа ижил элементийн гарал үүслийн асуудлыг нарийн судлаагүй өрөөсгөл

“дүгнэлт”-ийг хийсээр иржээ. Ер нь Алтай судлалын гол асуудал нь түүнд хамааруулан судлаж байгаа хэлүүдийг шинжлэх ухааны өндөр түвшинд өөрийг нь болон өөр хоорондоо харьцуулан судлаж, шинжлэх ухааны талын мэдээллийн хүрээг тэлэх явдал болохоос нэг язгуураас эх авсан эсэхийг нь батлах юмуу үгүйсгэх нь гол асуудал биш юм. Иймд алтай судлалд онолын шинэ хандлага бий болгох нь чухал бөгөөд алтайн аль хэлний үндсэн элементийн өөрчлөлт, нэгнээс нөгөөд шилжих, эс шилжих элемент, биосфер, хүний ерөнхий өгөгдөхүүнээс улбаалан гарцаагүй ижил байх зүйлс /хэлийг тэр хүн хэл бүхэнд эгшиг, гийгүүлэгч, авиа залгавар, дагавар гм/ байхыг анхааран судлаваас зохимжтой.

Алтай хэлүүдийн ижил төстэй элементүүд нь яаж, хэзээ бий болов. Энэ нь язгуурын нэгтэй юм уу, зээлсэний баталгаа юм уу? Аль эсвэл биосферийн хүрээнд хүний биеийн ерөнхий өгөгдөхүүнд тулгуурласан хэлний үндсэн нэгж нь магадлалаар ижилсэх явдал уу?

Аль талаар авч үзсэн ч бай алтай судлалд тодорхойгүй, нарийн төвөгтэй, олон учир шалтгааныг тооцоолон үзэх явдал чухлаар оршсоор байгаа юм. Иймд хүн төрөлхтөний хэл, үүсэн бий болсон болон бодит хэлүүд бий болон хөгжсөн түүхийг нягт холбоотойгоор, өөр бусад зүйлийг анхаарах хэрэгтэй билээ. Жишээбэл, нэрт эрдэмтэн Н.Н.Поппе өөрийн сонгодог бүтээлдээ, өвөг алтай хэлний гийгүүлэгч авиаг дараах байдлаар сэргээн 18 фонемийг үзүүлсэн байдаг билээ.<sup>2</sup> Хавсаралт №1-д үзүүлэв.

Эдгээрээс үзэхэд эдгээр хэлний эгшиг, гийгүүлэгч авиа ижил төстэй болох нь харагдаж байна. Хэрэг дээрээ үүнийг эдгээр хэлний ижил элемент гэхээсээ илүү хүний өгүүлэх эрхтний боломжит боломжинд тулгуурласан авиа гаргах явц гэж бас авч үзэж болох юм. Хүн авиаг гаргах явцыг нэг мөр сураагүй бөгөөд Францын эрдэмтдийн судалгаагаар 750 мянган жилийн өмнөх хүн “у, а, и” авиаг хэлж чадахгүй байсан мөртлөө “е, м” авиаг хэлж чадаж байжээ. Учир нь тэр үеийн хүмүүсийн махан хэл нь одоогийн хүнийхээс богино байсан байна. Анхны хүмүүсийн сүрэг нь нэг нэгтэйгээ харьцахдаа гар хөлөөр, толгой дохих, гар даллах зэрэг биеийн хөдөлгөөнтэй зохицуулан, хэлээрээ “эгшиг /v/, гийгүүлэгч /c/ авиа”, буюу “с”, “v”, “cv” типээр харьцаж байжээ. Энд бол v, cv хэв шинж авиаг үг болж хүмүүсийн хоорондоо харилцааны хэрэгсэл болж, диакрон цагийн үүднээс авч үзвэл, нэн эртнээс 800000 жилийн өмнөх урт үеийг хамаарчээ. Энэ үед хүн сүргийн нэг хэсгийн хэрэглэх “авиа-дохио” нь нөгөө хэсгээс зээлдэн авах шаардлагагүй, зөвхөн хүн өөрийн биеийн хөдөлгөөн, авиа гаргах боломжит боломжинд тулгуурлаж байсан “өөрийн бүтээл” байх нь ойлгомжтой юм. Тэгвэл түрэг, монгол хэлний /” дохионы хэл”/ хувьд дохио - авиа, авиа - дохио хэлний үе нь нилээд удаан үргэлжилсэн бололтой. Диахрон болон синхроны байдлаар авч үзвэл, түрэг юм уу

монгол хэлэнд язгуур морфем болон заагаар морфем нь тэр үед бүрэлдэн одоо хүртэл үгсийн сангийн бүтцийг баяжуулсан “язгуур хэлний элемент” v, cv, c тип болж байгаа юм.

I. Хүн төрөлхтөний ярианы хэл бол авианы хэл. Хүний анхны сүрэг “дохио-авиа”-ны хэлээр харьцах үе нь асар урт удаан үеийг эзэлсэн тул тэр нь маш баг бөх бэхжсэн учир дараа дараагийн үед түүнийг хүмүүс уламжилан хэрэглэхээс үндсээр өөрчлөх боломжгүй болдог байна. Гэвч, цагийн уртад нийгэм-түүхийн хөгжлийн явцад тэр нь тоо болон чанарын хувьд хувиран өөрчлөгдөж ирсэн болох нь ойлгомжтой.

II. “Дохионы хэл”-ний дараа “богино үг” хэлний үе үргэлжилсэн байна. Энэ үед v, cv хэв шинжтэй авиа язгуур морфемээс vc, vcv, vcc, cvc, cvcv, cvcc хэв шинжит язгуур үгнүүд аажмаар бүрэлдэж эхэлжээ. Эдгээр язгуур үгүүдийг өөр хоорондоо харилцахад орчин үеийн залгавар, залгаваргүй цувуулан, богино авианы бүрдэлтэйгээр шууд дуудаж байжээ. Энэ үе нь бараг 800000-40000 жил хүртэл үргэлжилсэн бололтой.

III. “Нийлмэл үгийн үе” vc, vcv, vcc, cvc cvcv, cvcc, cvccvcv, cvcvcv хэв шинжит язгуур үгүүдийг хоёр юм уу гурван үгийг үгийн холбоо маягаар, богино өгүүлбэр хэлбэрээр хэрэглэжээ. Энэ үед хүний танин мэдэхүйн хүрээ өргөжин, байгаль орчин, нийгмийн үзэгдлийг танин мэдэж, үгсийн санд юмсын нэр, хөдөлгөөнийг нэрлэх үг, хийсвэр ухагдахууныг илэрхийлэх боломж өсчээ. Энэ үед дэлгэрэнгүй өгүүлбэр бүрэлдэж, нийлмэл санааг илэрхийлэх боломжтой болжээ. Энэ үе бол 40000-10000 жил үргэлжилжээ.

IV. Орчин үе нь 10000 жилээс хойшхи үеийг хамаарч байна. Энэ үед цаг хугацаа болон орон зайн шинжүүдийн тодорхой нэг хэлбэр нь хүний оюун санаанд байгалийн нэгдмэл байдлаар төсөөлөгдөх болжээ. Цаг хугацаа өтгөрөн шахагдаж, тэгээд гоо сайхнаар нүдэнд тусах болж, харин орон зай бол бөөгнөрөн, түүхийн санаа, цагийн хөдөлгөөнд захирагдана. Цагийн шинжүүд орон зайд нээгдэж, орон зай цагаар хэмжигдэн, цаг хугцаагаар дамжин ойлгогдоно.

Алтай хэлүүдийг тээгч одоогийн угсаатан, үндэстнүүдийн өнгөрсөн түүх нь нэн эртнээс эхтэй тул тэд гарал угсаа нэгтэй салбарлан өсөж, хэл нь дагаж нэгдмэл язгууртай байх боломж ч байгаа билээ. Үүнийг дэлхийн гадаргууд аж төрөгч хүний тоо палеолит, неолит, энолитийн үед тийм ч олон байгаагүйгээр бас тайлбарлаж болох юм.

Алтай язгуурын гэж буй хэлүүд, түүний дотор казах, монгол хэл нь залгамал хэв шинж, түүний дотоод хуульд тулгуурлан хөгжжээ. Эдгээр хэлүүдийг судлахад ХХ зууны хэл шинжлэлийн ололтууд, ялангуяа, морфемийн онол, бүтэц зүй гэх мэт зэрэг нь хүчтэй нөлөөлсөн байна. Алтай хэлүүдийг судалсан олонхи шинжээчид нь морфем гэдэг ойлголтонд үг, дагавар, залгаварыг багтаасан хэлний хамгийн бага

утга бүхий хэсэг бөгөөд тэр нь өөрөө мөн язгуур, үндэс, залгавараас бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Үгсийн сангийн /лексик/ агуулга бүхий хэсэг нь язгуур морфем, өгүүлбэр зүйн /грамматик/ агуулга бүхий хэсэг нь залгавар морфем болно. Ерөнхий хэл шинжлэлээчид болон монгол, түрэг хэл шинжээчид үзэж байгаагаар алтай хэлний үгийн язгуур, үндэс, залгавар, дагаварыг нэг адил морфемд багтаан үздэг.

1. Гэвч хэрэг дээрээ, казах, монгол хэлэнд үгийн бүтцийн хэлний авиа бүр үгийн утгыг ялгаруулдаг үгийн ширхэг нь /piece/ болдог. Энэ нь алтай хэлний бүр “дохио-авианы” хэлний үе шатнаас уламжлагдсан байна.

2. Хэлний хөгжлийн явцад авианууд *c, v* болон *cv* хос авианы цуваанд орж, үгийн агуулга бий болгож, бие даасан лексемийн түвшинд хүргэжээ. Энэ нь “богино үгийн” үед холбогдоно.

3. Хэлний хөгжлийн явцад *c, v* болон *cv* авианууд үг ба үгийн энгийн ба нийлмэл өгүүлбэрийг бий болгожээ. Түрэг, монгол хэлний авианы энэ агуулга нь синтаксисийн үүрэг юм.

4. Хэлний авиа нь синтаксистик түвшинд хүрэхэд хөгжлийн асар урт удаан хугацаа шаардагдсан бөгөөд энэ нь “нийлмэл үгийн” үе шатанд хамаарна.

Үнэн хэрэг дээрээ хэлний үндсэн /фонем, морфем, үг, өгүүлбэр/ дөрвөн элементийн хэлний бүтэц дэх үгийн агуулга хэлбэр, тоо, байрлалын хувьд анхааран эдгээр дөрвөн элементийн нэгжийн тогтолцооны ойлголтыг ажиглавал, алтай хэлүүдийн бүтцийн дөрвөн элемент нь дараах байдалтай байж болох юм.

1.1. Фонем-хэлний бүтцийн хамгийн бага нэгж, морфем болон үгийн агуулгыг ялгаруулж, бүтцийн хувьд *v, c* тип бүхий хэлний авиа юм. Тооны хувьд үгийн бусад гурван элементээс хамгийн цөөн, байрлалаар нь үгийн хэлбэрийн бүтцийн элементийн анхны нэгжийн тогтолцоо болно.

1.2. Морфем хэлний бүтцэд агуулгын байгууламжийн хувьд фонемээс багтаамжтай /их/, үгнээс багтаамжгүй /бага/ элемент болно. Агуулгын хувьд үгийн адил бие даасан агуулга үгүй, тодорхой асуултанд хариулагддаггүй, өгүүлбэрийн гишүүн болж чаддаггүй зөвхөн морфологийн түвшинд үгийн агуулгыг синтетик аргаар бий болгодог, синтаксисийн түвшинд синтетик болон аналитик аргаар үгүүдийг, үгийн холбоос, өгүүлбэрүүдийг холбодог фонемийн дарах нэгжийн тогтолцоо юм. Хэлбэрээр *v, c, cv* хэв шинжит хэлний авиа. Тооны хувьд фонемээс олон, үгнээс цөөн. Байрлалаар үгийн бүх /эхэн, дунд, адаг/ орчмоор болон үгүүдээс, нийлэмж үг өгүүлбэрийн дараа зааг барин байрлаж, тэдгээрийг холбож байдаг нэгж юм.

1.3. Үг нь хэлний бүтцийн элементийн агуулгын багтаамжаар морфемээс их, өгүүлбэрээс бага, нарийн элемент. Агуулгаар тодорхой

асуултанд хариулагддаг, бие даасан агуулгатай, өгүүлбэрийн гишүүн болдог, хэлбэрээр нь с, v, cv хэв шинжтэй морфемээс бүрдсэн, тооны хувьд морфемээс их, өгүүлбэрээс бага болно. Үг хэлний элементийн морфемээс их, бие даасан, нарийн нэгжийн тогтолцоо юм.

1.4. Өгүүлбэр хэлний бүтцийн элементийн агуулгын хувьд үгнээс багтаамжтай /их/, хамгийн нарийн элемент. Агуулгын хувьд хүмүүсийн /яригч болон сонсогчийн/ өөр хоорондын харилцаанд бодол санааг энгийн болон нийлмэл аргаар илэрхийлдэг, хэлбэрийн хувьд бие даасан үг, үгүүд, нийлэмж үг болон өгүүлбэрүүдээс бүрдсэн, тооны хувьд тооцоолоход үгнээс их байна. Өгүүлбэр нь хэлний бүтцийн элементийн үгнээс багтаамжтай, хамгийн нарийн төвөгтэй нэгжийн тогтолцоо юм. Өгүүлбэрийн агуулгын хувьд авч үзвэл, өгүүлбэр нь хэлний дөрвөн элементээс, яг онож хэлбэл хамгийн бага нэгжийн тогтолцоо руу залгагдан, өгүүлэгч болон сонсогчийн өөр хоорондын харилцаанд агшин зуурын хугацаанд мэдээлэл дамжуулан, хүлээн авдаг, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх бололцоо олгох хэлний системийн нарийн төвөгтэй элемент нь юм.

Казах, монгол хэлний морфемийн бүтэц. Казах, монгол хэлний хөгжлийн диахрон болон синхроны хувьд хэлний морфемүүдг анхааран үзвэл:

1. Язгуур морфем-бүтцийн хувьд v, cv хэв шинжтэй, өөр вариантгүй, бие даасан байна. Агуулгын хувьд үгийн хамгийн үндсэн язгуур агуулгыг илэрхийлэхэд тэмүүлэх шинжтэй цаашид задлах бололцоогүй, /зөвхөн фонемд/ байрлалын хувьд ямагт үгийн эхэнд байдаг, юмс, үзэгдэл тэдгээрийн шинж чанар болон хөдөлгөөний нэр үг болох, өөрөөр хэлбэл, лексикийн бие даасан агуулгагүй асуултанд хариулагддаггүй, өгүүлбэрийн гишүүн болдоггүй хэлний нэгжийн тогтолцооны элемент юм. Язгуур морфем /v, cv/ оролцдоггүй бие даасан үг гэж байхгүй. Ер нь алтай язгуурын хэлэнд v, cv энгийн язгуур морфемууд, эдгээр хэлүүдийн анхны дундын язгуур элемент нь байсан бөгөөд одоо хүртэл үгийн хамгийн эхэнд хадгалагдан, үгсийн сангийн үндсэн анхны үндэс байсан гэж дүгнэж болох юм.

2. Нэмэлт морфем-бүтцийн хувьд v, c, cv тип бүхий авиа, вариантгудтай, бие даасан агуулгагүй, байрлалаар нь v, cv тип бүхий язгуур морфемийн дараа байрлана. Морфологийн түвшинд язгуур морфемд залгагдан, үндсэн язгуур үг бий болгоно. Синтаксисийн түвшинд үг, нийлэмж үг, өгүүлбэрийг холбодог, тооны хувьд ганц нэг нэмэлт морфемууд тогтвортой, нийлмэл нэмэлт морфемууд тогтворгүй байна. Алтай язгуурын хэлний язгуур морфемийн тогтолцоог хавсралт №2-г үзүүлэв.

Казах, монгол хэлний язгуур морфемууд. Диахрон болон синхроны үүднээс авч үзэхэд казах, монгол хэлний v, cv тип бүхий язгуур

морфемийн тоо бараг ойролцоо юм. Гэхдээ энэ хоёр хэлний хөгжлийн хамгийн эртний үед нийтлэг байсан анхны морфем –о байсныг хэлбэл зохино. Богино үгийн үед –явах- холдох- гэсэн нийтлэг агуулгыг заах язгуур үг монгол хэлэнд –”ода- оду” хэлбэрээр, казах хэлэнд “-озү –үза –озы” хэлбэрээр батжсан байна.

### Хүснэгт №1. Казах, монгол хэлний язгуур морфемийг харьцуулсан хүснэгт

морфемууд	ТИП НЬ	КАЗАХ	МОНГОЛ
эртний язгуур морфемууд	V Cv	8 90	8 88
орчин үеийн язгуур морфемууд	V cv	9 105	7 112

Өөрөөр хэлбэл, монгол, казах хэлүүдийн харьцангуй эртний үед унаган үгийн хамгийн эхэнд v тип бүхий найм /8/ язгуур морфем батжин бүрджээ. Энэ хоёр хэлэнд v тип бүхий язгуур морфем нь “дохио-авиа”-ны хэлний үед бүрэлдэн, орчин үе хүртэл хадгалагдан үлджээ. Эдгээр нь үгийн эхэнд тогтмол байрлаж уламжлан хадгалагджээ. Эдгээр нь

казах хэлэнд	A-e –o –ө-ү-ы-и
эртний монгол хэлэнд	A-e –o –ө-ү-ы-и

болно.

Эртний казах болон монгол хэлүүдэд эдгээр 8 язгуур морфемд c, cv тип бүхий нэмэлт морфемууд залгагдан, хоёр хэлний аль анхны дундын хамгийн үндсэн анхны язгуур үгүүд алтай язгуур хэлний “богино үгийн үед” бий болжээ.

Хоёр хэлний дундын ерөнхий агуулгыг илтгэх дараах үгийг харьцуулж болно.

### Хүснэгт №2. Монгол, казах хэлний хэлний дундын үг

Язгуур морфем	Казах хэлний агуулга	Монгол хэлний агуулга
ар-	1. урьдаас нь эсрэг тал 2. цэвэр	1. урьдаас нь эсрэг тал 2. цэвэр
ер-	1. эрэгтэй 2. араас нь дагах	1. эрэгтэй 2. араас нь эргэх
ор-	1. нулаг, орон 2. нүх, гуу	1. нулаг, орон 2. нүх, гуу
өр-	1. өндөр газар 2. өргөжих, томрох	1. өндөр газар 2. өргөжих, томрох
үр-	1. үргэлжлэх 2. үйл хэрэг	1. үргэлжлэх, залгамжлах
үр-	1. үргэлжлэх, залгамжлах	1. үргэлжлэх, залгамжлах
ыр-	1. юмнаас салах	1. юмнаас холдох
i р-	1. нэг юмтай салах	1. юмнаас холдох



3.2. Сv тип бүхий язгуур морфем. Сv язгуур морфем нь эртний бөгөөд үгийн эхэнд хадгалагдан, тогтвортой уламжлагдан, түүнд с, cv тип бүхий нэмэлт морфем залгагдан, энэ хоёр хэлний дундын хамгийн үндсэн анхны язгуур үгийн “богино үгийн үе”-д бүтээжээ. Дараах хүснэгтэд монгол, казах хэлний дундын язгуур нэг cv тип бүхий язгуур морфемуудыг хавсралт N3-д үзүүлэв.

1. Казах, монгол хэлэнд л, р, н-гаар казах хэлэнд й-гээр эхлэх cv язгуур морфем байхгүй, казах хэлэнд г, ғ, з-гээр язгуур морфем, монгол хэлэнд п-гээр эхэлсэн язгуур морфем зээлдсэн үгэнд тааралдана. Казах, монгол хэлэнд дээрхи хүснэгтэд үзүүлсэн cv язгуур морфемууд, үгийн эхэнд тогтносон байж, язгуур морфем бүрээс бие даасан агуулга бүхний үг бүтээнэ.

Ж: ка, ко, ку, кы язгуур морфемд лексикийн агуулга байхгүй, зөвхөн язгуур үг бүтэхэд бэлэн байна. Эдгээр 4 язгуур морфемд нэмэлт морфем –р- залгавал- кар- кор-, кър-, кыр гэсэн бие даасан агуулга бүхий дөрвөн үг бүтээнэ. Эндээс фонем бол язгуур морфем болон үгийн агуулгыг ялгадаг нь ажиглагдана.

Ү. Нэмэлт морфемууд

Ү.1. Дан ганц нэмэлт морфемууд. Казах, монгол хэлүүдийн эртний уугуул үгүүдэд алтай хэлний богино үгийн үед хэлбэржиж бүрдсэн, одоо хүртэл хадгалагдсан /авиа зохицох ёсыг оролцуулан/ дараах с, cv тип бүхий нэмэлт морфемууд байх ажээ.

#### V тип бүхий дан ганц нэмэлт морфемууд

казах хэлэнд	монгол хэлэнд
-а-	-а-
-е-	-е-
-о-	-о-
-ө-	-ө-
<hr/>	
-ү-	-ү-
-ў-	-ў-
-ы-	-ы-
-i	-i

Казах, монгол хэлэнд тохиолдох дан нэмэлт морфемуудыг хавсаргалт N4 үзүүлэв. Казах, монгол хэлэнд хавсралтанд үзүүлсэн cv тип бүхий нэмэлт морфемуудаас гадна зарим /-ha, -ho, -ho, -hy, -he гм/ аялга үгэнд орох нэмэлт морфемуудыг оролцуулан тооцвол, одоогийн казах, монгол хэлүүдийн v, с, cv тип бүхий нэмэлт морфемуудын тоо 140 орчим байна.

Энэ хоёр хэлний v, с, cv жин бүхий нэмэлт морфемуудын бүтэц: байрлал, утга ялгаруулах, тооны хувьд ижил байгаа нь типологийн төстэйх биш генологийн ижил төстэйн баталга болж байгаа юм.

IV.2. Нийлмэл нэмэлт морфемууд. Казах, монгол хэлүүдэд дээр дурдсан v, c, cv типт нэмэлт морфемуудаас гадна тэдгээр нь өөр хооронд нийлэн нэгдэж, нийлмэл нэмэлт морфемууд /залгавар, дагавар/ бүтээнэ. Нийлмэл нэмэлт морфемуудийн бүтэц, тооны хувьд v, c, cv нэмэлт морфемууд шиг тогтвортой биш, хэд хэдэн нэмэлт морфемээс нийлмэл нэмэлт морфемууд нь:

1. Язгуур v, cv-морфемуудад залгагдан, эд юмс, хөдөлгөөн, шинж чанар, тооны шинж бүхий янз бүрийн нэмэлт ойлголт бий болгох үндсэн язгуур болон үүсмэл үгнүүд бүтээнэ.

2. Язгуур үгүүд болон үүсмэл үгүүд ярианы цуваанд оролцон, нарийн бодол санал илтгэхдээ тэдгээр үгийг субъект, объект, предикаттын харилцааг заана. Казах, монгол хэлний нийлмэл нэмэлт морфемуудын тоо ойролцоогоор 600 байж хоёр хэлний морфологийн бүтцэд эртний казах, эртний монгол хэлний язгуур морфемууд болон нэмэлт морфемуудын авианы тогтолцоо, агуулга, байрлал, тоо нь ижил тэнцүү байгаа нь нотлогдож байна.

Хоёр хэлний нийлмэл нэмэлт морфемууд нь диахрон байдлаас авч үзэхэд –cvc, ccv, cvcc, cvcv, cvcvc, cvccv, cvccvc, cvcvcvc, ccvcvcvcvcvc, ccvcvcvcvc- гэх мэт гэхэд хэдэн жин бүхий юм.<sup>3</sup>

V. Казах, монгол хэлнүүдийн морфемуудын семантик.

V.I. Язгуур морфемуудын семантик. Алтайн хэлнүүдийн v, cv тип бүхий язгуур морфемууд нь эртний хүмүүсийн харилцаанд хэрэглэхдээ өөрсдийгөө хүрээлэн буй байгаль орчинд нүдэнд харагдах /сонгогдох мэдээлэл олох, эд юмс, үзэгдлийн зай хэмжээ, хэлбэр дүрсийг хөндлөн талбайн чиглэлээр “өөрөөсөө алс, өөрт нь ойроор нь, эгц чиглэлд “өөрөөсөө дээр, доор” байгаагаар, мөн “өөртөө” байгаа хэлбэр дүрсээр маш энгийн мэдэрч ойлгож байсан нь харагдана.

Жишээ нь казах, монгол хэлний -a- язгуур морфем нь яригчийн “өөрөө”, ам ауыз өөрийнх ойр төрөл /аав, ах, амраг/, түүнээс зүг чигийн байдал /ар/, түүнд өөр нэгэн биет ойртох болон холдох г.м, ка-язгуур морфем нь мөн “өөрөө” /хамар, хацар, хавирга” ойр төрлийнх /хадам, хатан, хамаатан/ түүнээс холдох /хагацах/ гм, ке-язгуур морфем нь орон зайн баримжаа хөдөлгөөний хязгаар гм зааж бэхжсэн байна.

Дээрхийн адил казах, монгол хэлний v, cv, тип бүхий язгуур морфемуудад 1. Яригчийн “өөрөө” бусдын өөрт нь хамаарал, байрлал, 2. яригчийн чиглэсэн зүг чигийн тухай түгээмэл ойлголт хадгалагджээ. c, cv тип бүхий морфемээс бүтсэн үндсэн язгуур үгнүүд, үүсмэл үгүүд гм дээрхи хоёр нийтлэг агуулгад бүрэн хамаарагдаж байна.

V.II. Нэмэлт морфемуудын семантик

Казах, монгол хэлүүдэд v, cv тип бүхий 140 орчим нэмэлт морфем болон бүх вариантуудын хамтаар 600 нийлмэл нэмэлт морфем байгаа

ажээ. Язгуур морфемийн 1. тогтмол байрлал 2. тогтмол чиглэлийн хоёр семантикийн агуулгад хөдөлгөөний чиглэл болон хөдөлгөөний чиглэлийн хязгаарын тухай нийтлэг ойлголт нэмэгдэнэ. Жишээлвэл, казах, монгол хэлний гарал үүслийн асуудлыг алтай хэл шинжлэлийн хүрээнд авч үзэхдээ зүгээр хэлний хөгжлийг гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөг тусган үзүүлэхийн хамтаар, гарал үүслийн асуудлыг дахин нягтлахыг оролдон, нэгтгэн дүгнэхийг чухалчилав.

- Гадаад хүчин зүйлийн хувьд орон зай, цаг хугацаа хөдөлгөөнийг

- Дотоод хүчин зүйлд орон-зай-цаг-хугацаа-хөдөлгөөний явцад эдгээр хэлний тээгчийн хувьсал, хэлний дотоод хөгжлийн зүй тогтолыг үзүүлэв.

- Эдгээр хэлний дотоод хөгжлийг дохио-авиан хэлний үед анх /лавтай 750000 жилээс хойш/ v /типийн авиа/ -8 /анхандаа нэг юм уу 3/, cv /эгшиг+гийгүүлэгч авиа/ - давхар авиа 120 илүү байжээ.

- “Богино үгийн үе”-д анхны язгуур үгүүд бий болж, тэдгээр үгээр богино дуудсан харилцжээ.

- “Нийлмэл үгийн үе”-д үгсийн сан баяжиж, бүтэц нь нарийн болжээ.

- Орчин үед эдгээр хэлнүүд нь өнөөгийн дүр төрхийг олж, хэрэглэгдэн, өөрчлөгдөн хөгжсөөр байна.

- Казах, монгол хэлэнд 8 эгшиг авиа, 17 гийгүүлэгч авиа бүрэлдэн батжиж өнөөдрийг хүрч ирсэн ба дуудлага, агуулга бүрдүүлэх нь ижилхэн байна. Казах, монгол хэлэнд 140 орчим дагавар, залгавар хөгжлийн явцад батжин, одоо 600 орчим болсон бөгөөд агуулга бүрдүүлэх нь адил төстэй казах, монгол хэлэнд үгсийн сангийн 3000 илүү дундын үндсэн язгуур үг байгаа бөгөөд 1520 нь бүтэц, агуулгын хувьд адилхан, 1480 орчим нь авианы хугарал, авиа сэлгэгдэх үйл явцад өртжээ. Тэгэхдээ, тэдгээр нь ерөнхий агуулгын хүрээнд ижил төстэй байна. Диахрон болон синхрон цагийн хувьд авч үзэхэд казах, монгол хэлний үндсэн үгсийн сангийн 20% нь “k, k, ɣ, ɣ” фонемээр эхэлсэн үгүүд юмуу эдгээр авианаас эхэлсэн үгүүдийн язгуур үг бөгөөд авианы бүтэц, үндсэн агуулгын хувьд ижил байна. Энэ нь алтай язгуурын хэлнээс казах, монгол хэл зааглагдах үед тэдгээр нь “хөөмийн” хэл байсныг харуулж байгаа бөгөөд нилээд эртний үед хамаарагдаж байна.

Хоёр хэлний өгүүлбэрийн бүтэц ч мөн адил юм. Иймд эдгээр олон тооны адилхан зүйлийн харгалзан үзэж, монгол, казах хэл нь гарал үүсэл нэгтэй төрөл хэл гэж үзэх үндэстэй болж байна. Алтай язгуур хэлний бүрэлдэхүүн хэсэг монгол, казах хэл нь нэг гарал үүсэлтэй, лавтайяа 10000 жилийн өмнө нэг хэл байсан нь бүхий талаар батлагдаж байгаа нь алтай хэлүүдийн нийтлэг элементүүд нь нэг эх үүсвэртэй гэж болохоор байгаа юм. Казах, монгол хэлүүд хэдэн зуун мянган жилийн эволюцийн хөгжлийн шатыг ярианы шалгуурыг дамжин

бүрэлдсэн ч гэсэн алтай язгуурын төрөл хэлнээс эхэлсэн хамгийн эртний мөн чанар, үндсийг хэвээр хадгалсан байна.

Гэхдээ эдгээр хэлүүд чухам хэдийд бие даан хөгжих болсон, түүний дараах дотоод хөгжлийн явц, адил бус зүйл юу байна, тэдгээр нь юунаас шалтгаалсан зэрэг асуудлууд байсаар байгаа юм.

Алтай хэлүүд цаашид судлагдсаар байх бөгөөд мөн асуудалд шинжлэх ухааны бусад салбарын ололтыг ашиглан шинэ шинэ онол, бүтээл, байр суурь төрөн гарсаар, үнэнд ойртсоор байх болно.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Баскаков, Н. А. Алтайская семья языков и ее изучение М., 1981 /56-93/, С.А. Старостин. Алтайская проблема и происхождение японского языка. М., 1991. Проблема общности алтайских языков. Л., 1971. Рамстедт Г.И. Введение в алтайские языкзнание. Морфология. Сводеш М. Лингвистические связи Америки и Евроази- Этимология 64.М., 1965 Poppe N Vergleichende Grammatik der Altaischen Sprachen T1 Wergleichende Lautlehre Weesbaden. 1960 Урал Алтайн хэлний тухай онолын үндсийг Ф.Страленберг тавьсанаас хойш 280—аад жил улиран өнгөрөв. Энэ хугацаанд дэлхийн олон хэлээр хэдэн мянган судалгааны бүтээл хэвлэгджээ. Эдгээрээс В.Шоти, Ф.Е.Видеман, М.А.Кастрен, О.Бетлинг, Г.Винклер, Е.Д.Половниов, Г.И.Рамстедт, В.Ванг, О.Доннор, Ю.Немет, А.Вамбери, И.Буденц, Л.Легети, Р.К.Коллиндр, М.Рясянен, В.А.Котвич. Н.Н.Поппе, Д.Дечи, Б.Я.Владимирцов. А.М.Шербак, Дж.Клоусен, Г.Дерфер, Г.Д.Санжеев, В.И.Цинциус, Н.А.Сыранятинков. Д.Фокон-Фукс, Д.Синор, А.Дильчар, Х.Паасонен, М.Свалеш, П.Хайду, Ш.Хаттори, О.П.Супик, Н.А.Васкаков. Дж.Г.Киекбаев. С.А.Стростин гм нэрт алтай судлаачдын бүтээл нь уг судлалд жинтэй хувь нэмэр оруулжээ.
2. Poppe, 1960, С.А.Старостин. Алтайская проблема и происхождение японского языка.М., 1991.с.5
3. Б.Базылхан. Казах, монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй. А., т 25

## ХАВСРАЛТ

Хавсралий нөл				
p	b	m	r <sub>1</sub> , r <sub>2</sub>	l <sub>1</sub> , l <sub>2</sub>
t	d	n		
k	g	ŋ		
č	ǰ	h	s	j

	ТҮРК.	МОНГ.	ТМ	КОР.
*b	(*h-) > 0-, p	*p- > ср.-мо. h-, л.-мо. 0- *p- > -b- / -γ- (-0-)	*p-, p	p-, ph-, p(=b)
*b	*b-, b <sup>2</sup>	*b-, -b- / -γ- (-0-)	*b-, w	p-, w
*m	*b-, m	*m-, m	*m-, m	m-, m
*t	*t-, t	*t, *č (перед *i, *i), -d (в ауслауте в конце слова)	*t-, t	t-, th-, t(h)
*d	*j-, d <sup>2</sup>	*d, *ǰ (перед *i, *i)	*d-, d	t-, t(=d)
*n	*j-, n	*n-, n	*h-, n	n-, n
*r <sub>1</sub>	*-r-	*-r-	*-r- <sup>d</sup>	-l-(=-r-)
*r <sub>2</sub>	*-r <sub>2</sub> -(=-r-) <sup>3</sup>	*-r-	*-r-	-l-(=-r-)
*l <sub>1</sub>	*-l-	*-l-	*-l- <sup>d</sup>	-l-(=-r-)
*l <sub>2</sub>	*-l <sub>2</sub> -(=-l'-) <sup>3</sup>	*-l-	*-l-	-l-(=-r-)
*k	*q-/k-, -q-/-k-	*q-/k-, -q-/-k- ~ -G-/-g-, -G-/-g	*k- <sup>s</sup> , k	k-, k(=g)
*g	*q-/k-, -γ-/-g- <sup>2</sup>	*G-/g-, -G-/-g-/-γ-	*g- <sup>g</sup> , g	k-, k(=g)/h
*ŋ	*-ŋ-	*-ŋg-/-γ-, -ŋ	*-ŋ-	-ŋ-
*č	*č-, č	*č-, -č-, -s	*č-, č	č-, čh
*ǰ	*j	*ǰ	*ǰ <sup>7</sup>	č-, č(=ǰ)
*h	*j-, h	*n-, n	*h-, h	n-, *h <sup>8</sup>
*s	*s-, s	*s-, s	*s-, s	s-/h-, s <sup>9</sup>
*j	*j-, j	*j-/0(перед *i, *i), -j-/-γ-	*j-, j	j-(0), -j-

С. А. Старостин. с. 24-25

Алтын хаангийн шүтлэг, гишүүн  
дуртгалыг ажарууцсан нь

1.

АЛТ.	ТҮРК.	МОНГ.	ТМ	КОР.
*p'	0-(~j-), -p-	h-(~j-), -γ- ~ -b-	p	p-, p(h)
*p	b	h-, -γ-(~w-)	p-, -b-	p-, -w-
*b	b	b(~-γ-)	b-, -w-	p
*m	b-, m	m	m	m
*-w-	-0-, -b	-γ- ~ -b-	-w- ~ -j-	-0-
*t'	t	t, ḡ(i)	t(ḡi-)	t-, t(h)
*t	d-, t	d, ḡ(i)	d-(*ḡi-), t	t-, -r-
*d	j-, d	d, ḡ(i)	d(*ḡi-)	t-, -r-
*n	j-, n	n	n	n
*-r1-	-r-	-r-	-r-	-r-(=-l-)
*-r2-	-r2-(=-f-)	-r-	-r-	-r-(=-i-)
*l1	j-, l	l-/n-, l	l	n-, -r-(=-i-)
*-l2	-l2-(=-l'-)	-l-	-l-	-r-(=-l-)
*k'	k-, -k-(-g-)	k-, k-(-g-)	x-, k	k(/h-)
*k	g-, -g-(-k-)	k-, -g-	k-, g	k-, -0-(-h-)
*g	g	g-, -γ-	g	k-, -0-(-h-)
*ŋ	0-(~j-), -ŋ-	0- ~ j- ~ g-, -ŋg-// -γ-(-n-)	ŋ	n-, ŋ ~ 0
*č'	č	č	č	č-, č(h)
*č	d-, č	d-, č	č-, s	č
*š	j	š	š	č
*h	j-, h	n	h	n-, h
*s	s	s	s	s-/h-, s
*-j-	*-j-	-j-/-γ-	-j-	-j-
? *š	?	s	*š	?
? *z	j-	s-	*s-	s-

2.

АЛТ.	ТҮРК.	МОНГ.	ТМ	КОР.
*i	i ~ i	i	i	i
*e	e	e	e	a ~ e
*ä	a ~ ä	a ~ e	γ, ä	i ~ ä
*u	u ~ u	u ~ u	u	u ~ i
*ö	o ~ ö	o ~ ö	o	o(~i)
*i(e)(?)	i ~ i	i	i ~ u(o)	u ~ a
*u	u ~ u	u ~ u	u ~ u	u
*o	o ~ o	o ~ ö	ü(-ä), o	o(u)~ä
*a	a ~ ä	a ~ e	a ~ e	a ~ e

3.

АЛТ.	ТҮРК.	МОНГ.	ТМ	КОР.
*ia	a(ä)	i ~ a	ia	ä ~ i
*io	a(ä)	i(~ö)	o	o
*iu(*ue)	o ~ u	o ~ u	i	je
*ua	a(ä)	a(e)	u	u

Б. Базалхан

№ 2. Нэгдүгээр хэсэг /Хавсралт 2/

АТТ - алтайнх текстил, КТТ - мэне түркі тілдери,  
 КМТ - мэне монгол тілі, КМТМ - мэне тунгус-маньчжур тілдери  
 КМТ - мэне япон тілі, КМТ - мэне корей тілі.

1. "У" типті түбір морфема

АТТ.	КТТ	КМТ	КМТМ	КМТ	КМТ
а-	а-	а-	а-	а-	а-
о-	о-	о-	о-	о-	о-
у-	у-	у-	у-	у-	у-
й-	й-	й-	й-	й-	й-
е-	е-	е-	е-	е-	е-
ө-	ө-	ө-	ө-	ө-	ө-
и-	и-	и-	и-	и-	и-
і-	і-	і-	і-	і-	і-

ае-	аө-	аө-	аө-	аө-	аө-
оө-	оө-	оө-	оө-	оө-	оө-
уө-	уө-	уө-	уө-	уө-	уө-
йө-	йө-	йө-	йө-	йө-	йө-
еө-	еө-	еө-	еө-	еө-	еө-
өө-	өө-	өө-	өө-	өө-	өө-
иө-	иө-	иө-	иө-	иө-	иө-
іө-	іө-	іө-	іө-	іө-	іө-
еө-	еө-	еө-	еө-	еө-	еө-
өө-	өө-	өө-	өө-	өө-	өө-
иө-	иө-	иө-	иө-	иө-	иө-
іө-	іө-	іө-	іө-	іө-	іө-

2. "СУ" типті түбір морфема

АТТ.	КТТ	КМТ	КМТМ	КМТ	КМТ	КМТ
қа-	қа-	қа-	қа-	қа-	қа-	қа-
қо-	қо-	қо-	қо-	қо-	қо-	қо-
қу-	қу-	қу-	қу-	қу-	қу-	қу-
қи-	қи-	қи-	қи-	қи-	қи-	қи-
ке-	ке-	ке-	ке-	ке-	ке-	ке-
кө-	кө-	кө-	кө-	кө-	кө-	кө-
ки-	ки-	ки-	ки-	ки-	ки-	ки-
те-	те-	те-	те-	те-	те-	те-
то-	то-	то-	то-	то-	то-	то-
ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-
ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-
та-	та-	та-	та-	та-	та-	та-
ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-
ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-
та-	та-	та-	та-	та-	та-	та-
то-	то-	то-	то-	то-	то-	то-
ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-
ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-
та-	та-	та-	та-	та-	та-	та-
то-	то-	то-	то-	то-	то-	то-
ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-
ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-
та-	та-	та-	та-	та-	та-	та-
то-	то-	то-	то-	то-	то-	то-
ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-	ту-
ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-	ти-

қаө-	қаө-	қаө-	қаө-	қаө-	қаө-	қаө-
қоө-	қоө-	қоө-	қоө-	қоө-	қоө-	қоө-
қуө-	қуө-	қуө-	қуө-	қуө-	қуө-	қуө-
қиө-	қиө-	қиө-	қиө-	қиө-	қиө-	қиө-
кеө-	кеө-	кеө-	кеө-	кеө-	кеө-	кеө-
көө-	көө-	көө-	көө-	көө-	көө-	көө-
киө-	киө-	киө-	киө-	киө-	киө-	киө-
теө-	теө-	теө-	теө-	теө-	теө-	теө-
тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-
туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-
тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-
таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-
туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-
тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-
таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-
тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-
туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-
тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-
таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-
тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-
туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-
тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-
таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-	таө-
тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-	тоө-
туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-	туө-
тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-	тиө-

